



"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК

**"КАСК, МАЛГАЙ, НҮҮРГЭВЧ КАСК" НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт: "Каск, малгай, нүүргэвч каск"

Тендерын дугаар: ХА-041/2019

Улаанбаатар хот

ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Тендерийн нэр: **“Каск,малгай,нүүргэвч каск “ нийлүүлэх**
Тендерийн дугаар: **ХА-041/2019**

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **“Каск,малгай,нүүргэвч каск”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.**

Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 09 цаг 30 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 45.
УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба
Утас: 342420 +157, Факс: 976-341852
Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: "УБЦТС" ТӨХК
ТӨӨЗ 1.1	Тендерийн нэр дугаар: Каск,малгай,нүүргэвч каск ХА-041 /2019
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жилийн /2018 /оны аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлнэ 2. Сүүлийн нэг жил /2018 онд Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх. /гэрээгээр гүйцэтгэсэн гэрээний хуулбар,бараа хүлээлгэж өгсөн акт,гэрээ дүгнэсэн протгол ирүүлэх/ хөдөлмөр хамгааллын бараа материал хэрэгсэл зэргийг тооцно/ 3. Төсөвт өртөг: 37,899.400 төг Нэмэлт шаардлага 4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ 6. Үнийн саналыг маягтын дагуу баталгаажуулж ирүүлэх 7. Бараа нийлүүлэх хугацаа /хуваарь/ 8. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 9. ШШГЕГ-ын тодорхойлолт ирүүлнэ. 10. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэнэ. Захиалагч цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу татвар төлөлтийг, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана. 11. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. 12. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталогийн хувийг ирүүлнэ. Каталог дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ. 13. Тендерийн хэл нь Монгол хэл тул гадаад хэл дээрх аливаа материалыг баталгаат орчуулгаар баталгаажуулан орчуулж ирнэ. 14. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. 15. Олон улсын чанар стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчилэх, сертификатыг баталгаат орчуулгаар орчуулан хавсарган ирүүлнэ. 16. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл ирүүлэх шаардлагатай 17. Гэрээний үнээр,гэрээний хугацаанд хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 18. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.

ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр, 2 давхарт 206 тоот. Огноо: 2019 оны 03-р сарын 04 -ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр, 2 давхарт 206 тоот, Огноо: 2019 оны 03 дугаар сарын 04-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 3.1.д	<p>ТӨӨЗ-ны 3.1-д заасан материалаас гадна ирүүлэх шаардлагатай материал байгаа тохиолдолд жагсааж бичнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>
ТӨӨЗ 18.1 (д)	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Чанарын баталгаат хугацаа 6 сар байна.</p>

Гурав.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа	
1	2	3	4	5	6	7	8	
1	Цахилгаан нумнаас хамгаалах нүүргэвч /PSF BSEN166 .39-B /дүйцэхүйц	ш	231	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног		
2	Хатуулгатай саравчтай малгай /САРАВЧТАЙ МАЛГАЙ/	ш	601	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног		
3	Каска дуулга	Улаан	ш	1	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
		Цагаан	ш	16	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
		Шар	ш	55	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног	
4	Хошуувч /олон удаагийн/	ш	372	“УБЦТС” ТӨХК агуулах	шууд	14 хоног		

Техникийн тодорхойлолт

Толгой, нүүр хамгаалах хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага

Д/Д	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Зориулалт	Тайлбар
1	Дуулга /КАСКА/	<p>MNS 5621-2006 ISO, EN397, ISO EN50365 стандарт болон дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Механик үйлчлэлээс хамгаалах чадвар: 5 кг-ийн хагас бөмбөрцөг хэлбэртэй ачааг 1 м өндрөөс унагаж туршсан байна. 2.Цахилгаан гүйдлээс хамгаалах чадвар 1000В хүртэл 3.Температурын горим: -30°C:-+40°C 4.Дуулгын их бие:полиэтилен болон полипропиленээр (polypropylene, polyethelene) хийгдсэн байна. 5.Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга: 3ш байх ба дуулганд 6 цэгээр холбогдоно. 6.Дуулга нь бүчтэй байх бөгөөд чихний 2 талаар орж эрүүвчлэгддэг байна. 7.Хөлс шингээгчтэй байна. 8.Толгойд бэхлэгдэх хэсэг нь хэмжээг тохируулах тохируулгатай байна. 9.Каскны ар болон хажуу талаас харагдахаар гэрэл ойлгогчтой байна. (5 см өргөнтэй туузан) <p>Шар, цагаан, улаан өнгөтэй /тоо ширхэгийг захиалгаас харна уу/.</p>	Толгойг механик, дулааны, цахилгааны үйлчлэлээс хамгаална.	Нэгээс доошгүй агаар сэлгэлттэй байвал сайн. Толгой хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, хамгаалах хэрэгсэл гурав хоорондоо тохирсон байна.
2	Хатуулгатай саравчтай малгай /САРАВЧТАЙ МАЛГАЙ/	<ol style="list-style-type: none"> 1. ISO EN812 стандарт болон дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд: 2. Малгайны материал:хөвөн даавуу-80%, полиестер-20% байна. 3. Малгайн гадар болон дотор хэсэг агаар орох, агаар сэлгэх боломжтой /чийг татахгүй, хөлөргөхгүй/ байна. 4. Толгойны гадаргуутай харьцах хэсэг нь арьс цочроохгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. 5. Малгайны чангалах, суллах тохиргоо нь дагзны хэсэгт байрлалтай. 6. Хамгаалалт малгайнаас салдаг, малгай болон хатуулгыг угааж цэвэрлэх боломжтой. 7. Хар хөх өнгөтэй. 8. “УБЦТС” ТӨХК-ийн логотой байх ба малгайны гадна хэсэгт байрлуулсан байна. 	Өндрийн өөр түвшинд ажил гүйцэтгэдэггүй ажлын байранд өмсөнө.	Тендерт шалгарсан тохиолдолд логоо хэмжээ байршлыг зөвшилцөнө.

3	Цахилгаан нумнаас хамгаалсан нүүрэвч	ISO EN166 стандарт болон дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд: 1.Нүүрэвчний харааны зэрэг: 1 буюу хараанд өөрчлөлт өгөхгүй байх 2.Зурагдах, зүсэгдэхээс хамгаалагдсан байна. 3.Линзний зузаан 1,2мм-ээс багагүй байна. 4.Нүүрэвчний материал: поликарбонатаар хийгдсэн байна. 5.Нүүрэвчний өндөр нь 240мм-ээс багагүй байна. 6.Дуулганд бэхлэх боломжтой, дуулганд бэхлэгдэхдээ нумарсан байдлаар бэхлэгдэнэ. 7.Ультра ягаан туяаны шүүлтүүртэй /3/, гэрэл шүүх чадвар-1,2 химийн бодис /3/ болон цахилгаан нумнаас хамгаалсан /8/35кВ хүртэл 8. Металл хийц ороогүй	Цахилгаан тоноглолд сэлгэн залгалт хийх үед хэрэглэнэ.	Нүүрэвчний техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, нүүрэвч гурав хоорондоо тохирсон байна.
---	--------------------------------------	---	--	--

Д/Д	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Зориулалт	Тайлбар
4	Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /Тоосноос хамгаалах/	MNS 5620-2006 Амьсгалын замын хамгаалалтын хэрэслийн норм EN 149, 146,141, 140, 143, 148 стандарт нормын шаардлагыг хангасан байна. Үүнд: 1.Хамгаалах чадвар FFP-2 үзүүлэлтийг хангасан байх / MNS5620-2006 8.2.1.1/ 2.Тоосноос хамгаалах шүүгчийн давхар нь 10 ба түүнээс дээш байх 3.Амьсгал гаргах хавхлаг / клапан/-тай байх 4.Хамрын хянганы даруулга төмөр тохируулагчтай байх 5.Толгойд бэхлэх 2 резинэн уяатай байх 6. Хөлөргөхгүй, харшлахгүй ,амьсгалахад саадгүй ,чөлөөтэй байх 7. Хөнгөн уян хатан, хүний нүүрний хэлбэрт зохицсон байх	Амьсгал хамгаалах хэрэгсэл нь үйлдвэрийн тоос, химийн бодис, утаа угаар,болон хорт хийн бүтээгдэхүүнээс амьсгалын замын эрхтэнийг хамгаалах зориулалтын хэрэгсэл.	

Нийлүүлэгдэх барааны хувьд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалт хангаж байгаа эсэхийг техникийн үзүүлэлт бүрээр нотолсон үйлдвэрийн баримт /техникийн өгөгдөл буюу паспорт/, холбоо барих хаяг, и-майл хаягийг ирүүлнэ.

Тендерт оролцогч нь санал болгож буй барааны загварыг тендер нээхээс өмнө авчирч өгсөн байх шаардлагатай. / Загвар ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд барааг буцаах ба тус барааг сольж өгнө. Үүнтэй холбоотой гарах зардлыг захиалагч тал хариуцахгүй.

ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
гүйцэтгэх захирал Д.Баярсайхан танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ажлын 90] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Чанарын баталгаа, баталгаат засварын хугацаа 6 сар байна. Баталгаат засварын хугацааны барьцаа хөрөнгө гэрээний үнийн 5% байна.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Ирсэн барааны гэрээний үнийн 95 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш ажлын 90 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 2.1. Алданги оногдуулах хувь: **0,1%**.
Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10%-иас хэтрэхгүй**.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг ____ оны __ дугаар сарын ____-наас ____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.